



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/119

Хажуу шинэ ус

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Говь-Угтаал сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр (Завсарын хонд)-д байршилтай иргэн Гомбожавын Уянчимэг (ЗВ76010709)-ийн өвөлжөө хаваржааны зориулалттай 4807000678 нэгж талбарын дугаартай 5000 м.кв (0.5 га) газрыг иргэн Наранбаатарын Сумъяабазар (ЗВ95100114)-т зориулалтаар нь шилжүүлж 5 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Дээрх газрын эзэмшигч (Н.Сумъяабазар)-д эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Н.Лхагва-Учрал)-д, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Цэрэнчунт)-д үүрэг болгосугай.

3.Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу ашиглаж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч (Н.Сумъяабазар)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны А/89 дүгээр захирамжийн иргэн (Г.Уянчимэг)-д холбогдох хэсэг мөн газар эзэмших эрхийн 000505542 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.ДОРЖСҮМБЭР

482401119